



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/2/НА-СТА-ЗГТС

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Төлбөрийн акт	12
4.2 Албан шаардлага	13
4.3 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022 он 02 16 № 2107

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:\2022 он нармаа\гэрчилгээ\A4-toot.docx

0050?0191

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,843,889,945.00	1,567,454,397.00
33	АВЛАГА	1,843,889,945.00	1,567,454,397.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	6,117,795.00	3,617,000.00
335	Бусад авлага	1,837,772,150.00	1,563,837,397.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,837,772,150.00	1,563,837,397.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,843,889,945.00	1,567,454,397.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	41,051,700.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	41,051,700.00	-
413	Өглөг	41,051,700.00	-
4136	Бусад өглөг	41,051,700.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	41,051,700.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,802,838,245.00	1,567,454,397.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,802,838,245.00	1,567,454,397.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,802,838,245.00	1,567,454,397.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,758,053,163.00	1,796,720,450.00
51220	Тайлант үеийн үр дүн	44,785,082.00	(229,266,053.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,843,889,945.00	1,567,454,397.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,103,351,672.00	730,978,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156,312,572.00	7,388,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	156,312,572.00	7,388,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	156,312,572.00	7,388,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,312,572.00	7,388,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	947,039,100.00	723,590,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	387,605,950.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	387,605,950.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	559,433,150.00	723,590,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,759,050.00	39,749,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	428,674,100.00	683,840,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,058,566,590.00	960,244,453.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,058,566,590.00	960,244,453.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,697,100.00	44,297,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,032,100.00	6,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	6,548,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,665,000.00	37,749,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,752,000.00	29,724,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,913,000.00	8,025,000.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	991,869,490.00	915,946,803.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	442,687,105.00	631,303,281.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	442,687,105.00	631,303,281.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	156,312,572.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,312,572.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,700,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,086,420.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,086,420.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	365,083,393.00	284,643,522.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	365,083,393.00	284,643,522.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	44,785,082.00	(229,266,053.00)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	44,785,082.00	(229,266,053.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,474,546,265.00	730,978,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	527,507,165.00	7,388,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	527,507,165.00	7,388,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	527,507,165.00	7,388,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	371,194,593.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,312,572.00	7,388,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	947,039,100.00	723,590,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	387,605,950.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	387,605,950.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	559,433,150.00	723,590,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,759,050.00	39,749,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	428,674,100.00	683,840,900.00
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		281,334,753.00
145	Бусад орлого (олз)		281,334,753.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,474,546,265.00	1,012,313,153.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,474,546,265.00	1,012,313,153.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,697,100.00	44,297,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,032,100.00	6,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	6,548,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,665,000.00	37,749,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,752,000.00	29,724,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,913,000.00	8,025,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,407,849,165.00	968,015,503.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	876,635,405.00	679,754,981.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	876,635,405.00	679,754,981.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	160,012,572.00	3,617,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,312,572.00	3,617,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,700,000.00	

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,595.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,595.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	371,194,593.00	284,643,522.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	371,194,593.00	284,643,522.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	(281,334,753.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	281,334,753.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	281,334,753.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,802,838,245.00	1,802,838,245.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,802,838,245.00	1,802,838,245.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,802,838,245.00	1,802,838,245.00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,802,838,245.00	1,802,838,245.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-6,117,795.00	-6,117,795.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,796,720,450.00	1,796,720,450.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-229,266,053.00	-229,266,053.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,567,454,397.00	1,567,454,397.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
0	Төрийн сан		283,705,753.00	(283,705,753.00)	0.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		283,705,753.00	(283,705,753.00)	0.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого		283,705,753.00	(283,705,753.00)	0.0
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх		283,705,753.00	(283,705,753.00)	0.0
12	Татварын бус орлого		7,388,000.00	(7,388,000.00)	0.0
120	Нийтлэг бус татварын орлого		7,388,000.00	(7,388,000.00)	0.0
120042	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/		7,388,000.00	(7,388,000.00)	0.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		283,705,753.00	(283,705,753.00)	0.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого		(3,617,000.00)	3,617,000.00	0.0
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх		(3,617,000.00)	3,617,000.00	0.0
32	ЗГ-ын гадаадын төслийн зээл		279,934,753.00	(279,934,753.00)	0.0
321102	Үндсэн төлбөр / ЗГ-ын дотоод зээл/		279,934,753.00	(279,934,753.00)	0.0
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	723,590,400.00	722,652,631.00	937,769.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,590,400.00	722,652,631.00	937,769.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,749,500.00	39,749,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,749,500.00	37,749,500.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,724,500.00	29,724,500.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,025,000.00	8,025,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	683,840,900.00	682,903,131.00	937,769.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	683,840,900.00	682,903,131.00	937,769.00	99.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	683,840,900.00	682,903,131.00	937,769.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	723,590,400.00	722,652,631.00	937,769.00	99.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	723,590,400.00	722,652,631.00	937,769.00	99.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	39,749,500.00	39,749,500.00	-	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	683,840,900.00	682,903,131.00	937,769.00	99.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн бөгөөд 1-р гарын үсгийг Д.Амарсанаа, 2 дугаар гарын үсгийг Д.Алтанцэцэг нар зурж байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Халамжаас Хөдөлмөрт”, халамж хүртэгчдийг хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлж хандлагыг нь өөрчилж орлоготой болгох, амьжиргааг дээшлүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,058,566.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,878.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,114.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 14,403.7 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 276,435.5 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,843,889.9	1,567,454.4	(276,435.5)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,843,889.9	1,567,454.4	(276,435.5)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-	-
Нийт хөрөнгө	1,843,889.9	1,567,454.4	(276,435.5)
Өр төлбөр	41,051.7	-	(41,051.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,802,838.2	1,567,454.4	(235,383.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,843,889.9	1,567,454.4	(276,435.5)

Авлагын дансны үлдэгдэл 1,567,454.4 мянган төгрөг болж 276,435.5 мянган төгрөгөөр буурсан нь Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.03.04-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Илгээлтийн эзэн" аймгийн дэд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн

295 малчин өрхийн 287,600.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг чөлөөлж, хөнгөлөлт үзүүлсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,567,454.4 мянган төгрөг болж 235,383.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 6117.7 мянган төгрөгийн авлагын бууралт болон тайлант үеийн үр дүн 229,266.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,609,597.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,609,597.4 мянган төгрөгөөр буюу ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 19,200.0 мянга, ажилд зуучлах үйлчилгээнд 15,120.0 мянга, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрт 55,500.0 мянга, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 689,000.0 мянга, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт 422,500.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 157,370.0 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 89,400.0 мянга, бусад арга хэмжээнд 102,990.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 922,256.5 мянган төгрөгөөр бууруулж 640,840.9 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх зардалд 27,175.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд 562,221.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 2,100.0 мянган төгрөгийг анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 640,640.9 мянган төгрөгийн төсөв баталж, 3 удаа тодотгож улсын төсвөөс 683,840.9 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 3500.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрт 39,749.5 мянга төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 281,334.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрөөс 7,388.0 мянга төгрөгийг орлого бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гүйцэтгэлээр дээд шатны төсвийн захирагчаас 683,840.9 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрт 39,749.5 төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний бусад зардалд 39,749.5 мянга,

төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 678,354.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 937.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 722,652.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх зардалд 27,175.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд 649,565.9 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 7,100.0 мянган хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрт 39,749.5 мянга төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 6072 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, 2543 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлснээр 1358 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, 1226 ажил хайгч иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна.

Тайлант онд хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих төсөл хөтөлбөрт 58 иргэнд 130,000.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 20 иргэнд 64,000.0 мянга, малчдын хөдөлмөр дэмжих төсөл хөтөлбөрт 22 иргэнд 100,000.0 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсө эрхлэлтийг л хөтөлбөрт 14 иргэнд 33,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд нийт 3 зорилт 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 97.6 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийн иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулахад 130,000.0 мянган сая төгрөгийг баталсан. Гэвч аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/385 дугаар захирамжаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэгийг "Явган хүний хавтан үйлдвэрлэх", "Явган хүний зам талбай, хавтан тавих ажил", "Аймгийн төвийн ногоон байгууламж, ойн зурвас байгуулах ажил"-уудад төлөвлөгөө гарган баталж, Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг түшиглэж, 58 иргэнд дунджаар 2,500.0-2,800.0 мянган төгрөгийг төсөл сонгон шалгаруулалтгүйгээр нийт 130,000.0 мянган төгрөгийг олгосон. Эдгээр иргэдийг Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын байран дээр үйл ажиллагаа явуулсан байна. Уг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 3 жилийн хугацаанд орон нутгийн төсвөөс төлөх нөхцөлтэйгөөр гэрээ хийсэн байгаа нь дээрх хөтөлбөрийн 4.1 дэх заалтыг зөрчиж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитын код: БНА-2022/2/НА-СТА-ЗГТС

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,507,720.3 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хуулийн 6.4.5-д заасан 4,10,11 дүгээр саруудад 302,750.0 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээ, 11,12 дугаар саруудад 152,159.0 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, нийт 454,909.0 мянган төгрөгийн 9 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд урсгал төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 318,585.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 412,392.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 282,392.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах албан шаардлага, 130,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн 2015-2020 онуудын төлөлтийг тулгахад 282,392.1 мянган

төгрөгийн 176 зээлдэгч хугацаа хэтэрсэн байгаа нь Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.4 "Хүн амын зорилтот бүлгийн иргэдэд олгох санхүүгийн дэмжлэг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөлд заасны дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлсэн 6 дахь сараас эхэлж 48 хүртэлх сарын хугацаанд сар бүр эргэн төлөх нөхцөлтэй байна", 6.8 "Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ", мөн аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэнтэй байгуулсан гэрээний 3.10 "Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан эргэн төлөлт хийх хуваарийн дагуу Б тал эргэн төлөлтийг хугацаанд нь төлөх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчсөн тул санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан 4,10,11 дүгээр саруудад 302,750.0 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээ 11,12 дугаар саруудад 152,159.мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, нийт 454,909.0 мянган төгрөгийн 9 гүйлгээг тус тус мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг зөрчсөн тул санхүүгийн тайлангийн "Нийцсэн ба зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийн иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулахад 130,000.0 мянган сая төгрөгийг баталсан. Гэвч аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/385 дугаар захирамжаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэгийг "Явган хүний хавтан үйлдвэрлэх", "Явган хүний зам талбай, хавтан тавих ажил", "Аймгийн төвийн ногоон байгууламж, ойн зурвас байгуулах ажил"-уудад төлөвлөгөө гарган баталж, Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг түшиглэж, 58 иргэнд дунджаар 2,500.0-2,800.0 мянган төгрөгийг төсөл сонгон шалгаруулалтгүйгээр нийт 130,000.0 мянган төгрөгийг олгосон. Эдгээр иргэдийг Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын байран дээр үйл ажиллагаа явуулсан байна. Уг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 3 жилийн хугацаанд орон нутгийн төсвөөс төлөх нөхцөлтэйгөөр гэрээ хийсэн байгаа нь дээрх хөтөлбөрийн 4.1 дэх заалтыг зөрчиж байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Цаашид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	412,392.1			1	282392.1	1	0	1	130,000.0

_____оОо_____

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА,
ТЭМДЭГЛЭЛ

1. Тайлагнагч байгууллага

Энэхүү **Санхүүгийн тайлангаар** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна.

Санхүүгийн тайлагналын хугацаа нь 2021 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн 2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон.

2. Толилуулгын суурь

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Хорооноос бэлтгэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэлээ. Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг хэрэглэсэн болно.

4. Санхүүгийн тайлангийн бүрдэл

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үндсэн 5 нь тайлангаас бүрдсэн. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан
- Орлого, үр дүнгийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон тодруулга тайлангуудаас бүрдэнэ.

Дээрх тайлангуудын эхний үлдэгдэл нь 2021 оны мөн үеийн гүйцэтгэлээр илэрхийлэгдсэн.

Санхүүгийн байдлын тайлан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын тайлан нь эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө талдаа мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр талдаа жилийн хуримтлагдсан үр дүнг харуулж байна.

Аудитын нэр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

№	Баримт материалын нэр	Материал ирүүлэх хэлбэр	Баримт материал гаргаж өгөх ажлыг хариуцах ажилтны		Баримт хүлээлцсэн		Тэмдэглэл
			Албан тушаал	Овог нэр	Огноо	Хүлээлгэн өгсөн	
	Байгууллагын үйл ажиллагааны зорилго зорилт, тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
1	Байгууллагын үйл ажиллагаанд үйлчилдэг гол хууль эрхийн актууд, түүний заалтууд	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
2	Бүтэц, орон тоо баталсан шийдвэр	Цахимаар/ цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
3	Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны схем	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
4	Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ, хэлцэл, түүний хэрэгжилт, гэрээ дүгнэсэн материал	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
5	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр болон түүний тайлан	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, НББ-ийн дансны төлөвлөгөө, схем, тайлбарын хамт	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
7	Байгууллагад ашиглагдаж буй програм хангамжийн жагсаалт, МТ-ийн бодлого, журам	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
8	Байгууллагын 2021 оны жилийн санхүүгийн тайлан, тэмдэглэл, тодруулга, гүйцэтгэж байгаа баланс, журамнууд	Цахимаар/ цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
9	Байгууллагын батлагдсан төсөв, төсвийн тодотгол болон гүйцэтгэл	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
10	Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу төсөвт зохицуулалт хийсэн зардлын судалгаа	Цахимаар/ цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
11	Байгууллагын хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэл, дүн, тооллогын комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулсан акт	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
12	Авлага, өр төлбөрийн тооцоо үүсгэсэн баримт, тооцоо нийлсэн акт, эзэн холбогдогчгүй авлага, өр төлбөрийн судалгаа	Цахимаар/ цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
13	Өмнөх оны санхүүгийн тайлаг, эзлэлтийн зөвлөмж, акт, албан шараагийн биелэлт	Цахимаар/ цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
14	Мэргэжлийн байгууллагын шалгалтын дүгнэлт, үнэлгээний тайлан /СЯ, МХГ, Татвар, НДЕГ/	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
15	Дотоод аудитын нэржлийн 2021 оны төлөвлөгөө, тайлан	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
16	Татвар, нийгмийн даатгалын тайлан, тооцоо нийлсэн баримт	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
17	Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
18	Харилцах дансдын үлдэгдлийн баталгаа	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
19	Цалин, цалингийн нэмэгдэл, эзлэлийн амралттай холбоотой тушаал, шийдвэр, цалингийн тооцооны хүснэгт	Цахимаар/ цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
20	ТАИНС-ээс татсан цалингийн цэврт	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
21	Шилэн дансны мэдээллийн нэгдсэн тайлан	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
22	Сангийн яамын Э-тайланд шивсэн тайлан	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
23	Харилцах дансдын хуулга, төсвийн хэлбэлзэл	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
24	Ирүүлсэн баримт материалын жагсаалт	Цахимаар	нягтлан бодогч	Д.Алтанцэцэг			
25	Харилцахын баримт						
	Материалын тайлан						
	АЖС АМЧБОВ, МАБ ГЭРИЙН						

(Handwritten signature)

ХҮЛЭЭЖ АВСАН АУДИТОР

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН

Б.Нарангэрэл

Д.Алтанцэцэг